



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ  
АСУУЛГА

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг  
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон  
Утас: 26-70-16, Факс: 32-70-16  
E-mail: stategreathural@parliament.mn  
http://www.parliament.mn

2019. 11-04 № 25

Асуулга тавих тухай

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн хуралдаанаар Улаанбаатар-Дархан чиглэлийн авто замыг 4 эгнээ бүхий авто зам болгон өргөтгөн, шинэчлэх шийдвэрийг гаргасан. Уг шийдвэрийн дагуу Азийн Хөгжлийн Банкны "Бүс нутгийн авто зам хөгжүүлэх, засвар арчлалтын төсөл"-ийн 2 эгнээ авто замыг хүрээнд өргөтгөн, шинэчлэх ажил эхэлсэн. Энэ ажлын явц хэт удаашралтай явж иргэдэд хүндрэл үүсэж, түүнээс үүдэлтэй бухимдал маш их бий болоод байна. Мөн тоосноос үүдэлтэй байгаль орчны бохирдол асар их болж байна.

Иймээс уг замын ажилтай холбогдуулан Засгийн газраас хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар УИХ-ын тухай хуулийн 7.1.13-д заагдсан эрхийн хүрээнд Танд дараах асуулгыг тавьж байна. Үүнд:

1. Улаанбаатар-Дархан чиглэлийн авто зам 2019 оны 11 дүгээр сарын 01-нд ашиглалтад орох төлөвлөгөөтэй байсан. Яг хэдийд авто замын барилгын ажил дуусаж, ашиглалтад орох вэ?
2. Уг авто замын асфальтан хучилтын ажлын гүйцэтгэл 2019 оны 10 дугаар сарын 10-ны байдлаар 10 хувь хүрэхгүй байгаа гэсэн албан бус мэдээлэл байна. Ямар шалтгааны улмаас авто замын ажил удааширч төлөвлөсөн хугацаанд ашиглалтад орсонгүй вэ? Хэн буруутай вэ? Хуучин авто замын асфальтыг хэсэгчилж биш бүгдийг хуулсны шалтгаан юу вэ? Ажлын гүйцэтгэлийн талаар бодит мэдээлэл өгнө үү.
3. Авто замын барилгын ажлын ерөнхий гүйцэтгэгч болон туслан гүйцэтгэгчээр ямар компаниудыг хэн, хэрхэн сонгон шалгаруулсан талаар дэлгэрэнгүй мэдээллийг өгнө үү.
4. Улаанбаатар-Дархан чиглэлийн авто замын нэмэлт 2 эгнээг Европын сэргээн босголт, хөгжлийн банкны зээлээр барихаар хэлэлцээр байгуулсан. Уг ажил хэзээнээс эхлэх вэ? Нийт 4 эгнээ бүхий авто зам 100 хувь ашиглалтад хэзээ орох вэ?
5. Авто замын бүтээн байгуулалтын ажил хойшилж, шороон замаар маш олон тээврийн хэрэгсэл зорчиж байгаагаас тоосжилт их хэмжээгээр үүсэж, байгаль орчинд сөргөөр нөлөөлж байна. Энэ талаар хийсэн судалгаа байна уу? Энэ сөрөг нөлөөллийг арилгах чиглэлээр юу хийх вэ?

Асуулгын хариуг Монгол Улсын Их хурлын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.3 дахь хэсэгт заасан хугацаанд ирүүлэх улмаар Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар сонсгохыг Танаас хүсье.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ГИШҮҮН

Б. БАТТӨМӨР

0000000118